ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 26 өдөр Дугаар 100 Эрдэнэт

Хороодын ажиллах ажлын
чиглэл батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын Ээлжит II хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын үйл ажиллагаанд хэвлэмэл хуудас ашиглаж, хурлын тэмдэг дарахыг зөвшөөрсүгэй.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын хариуцах ажлын чиглэлийг нэгдүгээр хавсралтын ёсоор, үйл ажиллагаанд ашиглагдах хэвлэмэл хуудасны загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3.Хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ажлын чанар үр нөлөөг дээшлүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын дарга нарт даалгасугай

4.Хороодын үйл ажиллагааны зохион байгуулалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэцэцэг/-д даалгасугай.

ДАРГА П.ПҮРЭВЛХАГВА